



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2021 оны 35 болон 36 дахь долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 09-р сарын 23-наас 10-р сарын 10-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас 2 долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 15 дахь дугаарыг хүргэж байна. Энэ удаагийн дугаарт дэлхийн далайн тээвэр, логистикийн асуудал, БНХАУ-ын эдийн засагт бий болсон голлох өөрчлөлтүүдийг тоймлон эмхэтгэв.

### 1 ДЭЛХИЙН ДАЛАЙН ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН АСУУДАЛ

*Далайн тээвэр, логистикийн үнийн өсөлт юунаас эхлэлтэй вэ?*

- КОВИД-19 цар тахлын тархалтаас сэргийлэхийн тулд улс орнууд хилээ хааж, хөл хорио тогтоон, улмаар дэлхийн эдийн засгийн идэвхжил суларч, үйлдвэрлэл тасалдан, гадаад худалдааны эргэлт 2020 онд удааширсан билээ. Иймээс далайн тээвэр, логистикийн компаниуд зөөх ачааны хомсдолд орж, алдагдлаа бууруулахын тулд олон улсын тээвэр хийх онгоцны тоогоо цөөрүүлсний зэрэгцээ сул контейнероо эргэн татахаа багасгасан байна<sup>1</sup>.

Харин Азийн улс орнууд (ялангуяа БНХАУ) 2021 оны эхнээс цар тахлыг хяналтдаа авч, эдийн засаг нь сэргэн, үйлдвэрлэл, гадаад худалдаагаа тэлэх боломжтой болсон. Гэвч цар тахлыг хяналтад оруулж амжаагүй бусад орнуудад дотоодын хөл, хорио

үргэлжилж байсан тул контейнеруудыг Ази руу түргэн буцаах боломжгүй байв. Ийнхүү дотоодын хөл хорио, зохицуулалтын хязгаарлалт, боомт дээрх ажиллах хүчний хомсдол зэргээс шалтгаалан сул контейнерын түгжрэл бий болж эхэлсэн байна. Эрэлт талаас 1) цар тахлаас сэргийлэх дотоодын хөл хорио, хязгаарлалтын улмаас үйлчилгээний салбарууд агшиж, хэрэглэгчид үйлчилгээнээс бараа руу шилжих болсон, 2) Хөгжингүй улс орнуудад вакцинжуулалт эрчимжиж, эдийн засаг нь 2021 оны хоёрдугаар улирлаас эрчимтэй сэргэж байгаа нь гадаад худалдаа болон контейнерын эрэлт нэмэгдэхэд нөлөөлж байна. Улмаар Азид үлдсэн контейнеруудын дийлэнх нь Хойд Америк болон Европ руу бараа тээвэрлэн очсон ч мөн л цар тахалтай холбоотой боомтууд дээрх ажиллах хүчний хомсдол, нэмэлт хяналт


<sup>1</sup> Нэг улс нь цэвэр импортлогч тохиолдолд гадаад худалдааны тэнцвэргүй байдал бий болж, контейнерыг нэг талдаа хоосон буцаах шаардлага үүсдэг. Энэ нь тээврийн компаниудад ашиггүй тул тэд

сул контейнерыг зөөх сонирхол бага байдаг бөгөөд уг нөхцөл байдал цар тахлын үед улам даамжирч, сул контейнер хуримтлагдахад нөлөөлсөн.

шалгалт зэргээс шалтгаалан хуурай газрын депод болон далайн боомтуудад контейнерын түгжрэл даамжирч, Азийн бүс нутаг контейнерын хомсдолд ороод байна. Тодруулбал, сул контейнеруудын дийлэнх нь Хойд Америкийн төмөр замын депод болон далайн боомтууд дээр түгжрэлд орсон байдалтай байна. Одоогоор Азийн бүс нутаг хамгийн ихээр контейнерын хомсдолд орсноос гадна Европ мөн контейнерын дутагдалтай байна.

Drewry байгууллагаас тооцож зарладаг “Дэлхийн контейнер тээврийн нэгдсэн индекс”<sup>2</sup>-ийг харвал 2021 оны 9-р сарын байдлаар контейнер тээврийн үнэ өмнөх оны мөн үеэс 4.0 дахин өссөн байна (Дүрслэл 1). Түүнчлэн, БНХАУ-аас экспортлогдож буй ачаа тээврийн үнийг илэрхийлэх CCFI<sup>3</sup> индекс 9-р сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 3.2 дахин өсчээ.

Дүрслэл 1. Дэлхийн контейнер тээврийн үнийн индекс<sup>4</sup>



Эх сурвалж: [www.drewry.co.uk](http://www.drewry.co.uk), [www.statista.com](http://www.statista.com), [fbx.freightos.com](http://fbx.freightos.com)

Контейнер тээврийн үнэ нэмэгдсэн голлох шалтгаануудыг авч үзвэл:

- *КОВИД-19 цар тахал дэгдсэнээр үйлдвэрлэл болон эрэлтийн тэнцвэргүй байдал бий болсон.* Цар тахал дэгдсэний дараа улс орнууд хилээ хааж, зарим төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ сааруулсан нь олон улсын тээвэр гүйцэтгэдэг компаниудад тээвэрлэх барааны хомсдлыг үүсгэж байгаа бол

зарим саруудад үйлдвэрлэл нэмэгдсэнээр бараа тээвэрлэх сул чингэлгийн хомсдол бий болж байв.

- *Улс орнуудын эдийн засаг тэнцвэргүй (харилцан адилгүй) сэргэж байна.* Зарим улсуудын экспортын хэмжээ аль хэдийн цар тахлын өмнөх үеийг давсан байхад зарим улсуудад экспорт бүрэн сэргээгүй байна. Энэхүү тэнцвэргүй өсөлтөөс

<sup>2</sup> Drewry “Дэлхийн контейнер тээврийн нэгдсэн индекс” нь АНУ, Европ, Ази зэрэг 8 гол чиглэлийн стандарт 40 инчийн контейнер тээврийн дундаж үнийг нэгтгэсэн индекс юм.

<sup>3</sup> China Containerized Freight Index, SSE (Shanghai Shipping Exchange) буюу Шанхайн тээврийн биржээс гаргадаг тээврийн индекс

<sup>4</sup> Freightos “Дэлхийн контейнер тээврийн үнийн индекс” нь 40 инчийн контейнер тээврийн зах зээлийн үнэлгээг илэрхийлдэг индекс юм. Уг индекс нь Freightos-ийн тээврийн үнэлгээний онлайн платформ дээрх дэлхийн тээвэр зуучлалын компаниудын бодит цагийн, тоон мэдээлэлд суурилдаг. Сарын утгууд нь тухайн сарын сүүлийн 7 хоногийн ажлын 5 өдрийн дунджаар тооцогдсон.




шалтгаалж ойрын саруудад ачаагүй чингэлгийн тээвэрлэлт зэрэг худалдааны салбар, олон улсын тээврийн хүндрэлтэй асуудал үргэлжлэхээр байна. Энэ нь эргээд тээврийн зардал нэмэгдэхэд нөлөөлж байна.

- *Далайн тээврийг орлох өөр хувилбар байхгүй.* Далайн тээврийг орлох өөр хямд өртөгтэй тээврийн хувилбар байхгүй тул одоо үүсээд буй тээврийн зардлын өсөлтийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрч байна. Хэдийгээр агаарын тээврийн хэрэгсэл болон галт тэргийг ашиглаж болох ч тээж чадах ачааны хэмжээ харьцангуй хязгаарлагдмал бөгөөд цар тахлын энэ үед эдгээр тээврийн зардал мөн өсжээ. Тухайлбал, Baltic Exchange байгууллагаас тооцдог Хонг-Конг-Хойд Америк чиглэлийн агаарын ачаа тээврийн өртөг 2021 оны 9-р сарын байдлаар жилийн 85 хувиар өсч 9.74 \$/кг байна.
- *Өмнөх хямралуудтай харьцуулахад “КОВИД-19” цар тахлын үед гадаад худалдаа илүү богино хугацаанд сэргэсэн бөгөөд цаашид тогтвортой өсөх төсөөлөлтэй.* Тухайлбал, 2021 оны эхний хагасын байдлаар ихэнх бүс нутагт экспорт, импортын биет хэмжээ цар тахлын өмнөх түвшинд хүрч сэргээд байна.
- *Дэлхийн эрэлт сэргэж, боомтуудын хүчин чадлаас давахаар байна.* Далайн боомтууд дээрх нийт ачаа эргэлт 2021 оны 6-р сар хүртэлх 12 сарын хугацаанд өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өсчээ. Drewry байгууллагын төсөөллөөр боомтууд дээрх ачаа эргэлт 2025 он хүртэлх жилүүдэд дунджаар жилийн 5 хувиар өсөхөөр байгаа бол

боомтуудын хүчин чадал (хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн тооцоход) жилийн 2.5 хувиар л тэлэхээр байна.

- БНХАУ-аас АНУ-ын баруун эрэг хүртэлх контейнер тээврийн үнэ 2021 оны 10-р сарын эхний долоо хоногт өмнөх сарын мөн үеэс 20 хувиар буурлаа (Дүрслэл 2). Эрчим хүчний доголдолтой холбоотойгоор БНХАУ-ын үйлдвэрлэлүүд тасалдсан нь БНХАУ-аас контейнерын эрэлт түр хугацаанд буурахад нөлөөлөв. Гэсэн хэдий ч АНУ, Европын аж үйлдвэрлэлийн гинжин сүлжээн дэх БНХАУ-ын зарим захиалгууд бүрэн хангагдаж дуусаагүй хэвээр тул цаашид контейнерын эрэлт огцом буурахааргүй байна.

Дүрслэл 2. Контейнер тээврийн үнийн индекс<sup>5</sup>, гол чиглэлүүдээр



Эх сурвалж: [Freightos](#), [Bloomberg](#)

<sup>5</sup> 40 инчийн контейнер тээврийн зах зээлийн үнэлгээ, 7 хоногийн дунджаар



Контейнерын түгжрэл болон үнийн нөхцөл байдал ойрын хугацаанд шийдэгдэхээргүй байна. БНХАУ КОВИД-19-ын дотоодын тархалтаас сэргийлэх хатуу бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр байх нөхцөлд БНХАУ-ын томоохон боомтууд хаагдах, үйл ажиллагаа нь удаашрах эрсдэл хадгалагдсаар байна. Энэ нь

### Эх сурвалж:

1. VOA news, [China's Energy Crisis Puts Global Economic Recovery at Risk](#)
2. OPEC, [21st OPEC and non-OPEC Ministerial Meeting concludes](#)
3. Ship Technology, [Global shipping container shortage: the story so far](#)
4. ING, [5 reasons global shipping costs will continue to rise](#)
5. Hillebrand, [Where are all the containers? The global shortage explained](#)
6. The Wall Street Journal, [U.S. Ports See Shipping Reuters, Oil settles above \\$81 with OPEC+ sticking to output increase](#)
7. Fastmarkets, [Australia lowers iron ore price outlook below \\$100/t by 2022](#)
8. BIMCO, [Container shipping - onshore disruption leading to record delays and profits](#)
9. The Journal of Commerce online, [Global port congestion likely to last well beyond Q1 '22: Drewry](#)
10. Aircargo news, [Airfreight Rates – Baltic Exchange Airfreight Index](#)
11. SHIPSTA, [What is Empty Container Repositioning \(and What Causes It\)?](#)
12. Shipping and Freight Resource, [China-US freight rates plunge, but China manufacturing woes create new headaches for shippers](#)
13. DHL, [Ocean Freight Market Update](#)

## 2

## БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

*Эдийн засгийн голлох индексүүдийн өөрчлөлт*

- БНХАУ-ын 9-р сарын тоон мэдээлэл хараахан зарлагдаагүй байгаа бөгөөд Блүүмберг агентлагийн урьдчилсан төлөвөөр инфляц 0.9 хувь, үйлдвэрлэлийн инфляц 10.7 хувьд хүрэхээр байна. Түүнчлэн, экспорт 22 хувиар, импорт 20 хувиар өсөх хүлээлттэй.
- БНХАУ-ын 2021 оны 9-р сарын үйлдвэрлэлийн PMI 49.6 буюу өмнөх сараас 0.5 нэгжээр буурсан нь

үйлдвэрлэлийн салбарын идэвхжил суларч байгааг илтгэж байна.

*Төмрийн хүдэр*

- **БНХАУ-ын дотоодын төмрийн хүдрийн нийлүүлэлт 8-р сард өмнөх оны мөн үеэс 11.1 хувиар буурч 71.53 сая тоннд хүрлээ.** Нийлүүлэлт ийнхүү буурахад Хэбэй муж 16.09 сая тонн буюу 20.8 хувь, Шандон муж 5.48 сая тонн буюу 18.2 хувь, Жиангсу мужийн үйлдвэрлэл 7.97 сая тонн буюу 10 хувиар тус тус буурсан нь нөлөөлөв. Харин 2021 оны эхний 8 сарын байдлаар авч үзвэл үйлдвэрлэлийн

<sup>6</sup> Усан онгоц, далайн захиалгат тээвэр, усан онгоцны брокерын үйл ажиллагаа явуулдаг дэлхийн хамгийн том шууд гишүүнчлэлтэй байгууллага



хэмжээ нийт 605 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар нэмэгдсэн байна.

- **Австралийн нөөц эрчим хүчний байгууллагаас 2021 оны 9-р сарын тайландаа төмрийн хүдрийн үнийн төсөөллийг бууруулав.** Тухайлбал, 2022 онд 1 тонн төмрийн хүдрийн үнийн төсөөллийг 109 ам.доллараас 93 ам.доллар болгон буурууллаа. Гангийн үйлдвэрлэлийн гарц буурч байгаа болон БНХАУ-ын Засгийн газраас түүхий эдийн үнийн өсөлтийн эсрэг авч буй бодлогын нөлөөгөөр төсөөллийг бууруулах болсон тухай уг тайланд мэдээлэв.

*Ган, нүүрсний импорт, эрэлт, нийлүүлэлт*

- **БНХАУ 2030 он гэхэд нүүрс төрөгчийн хийг 65 хувиар бууруулах зорилтын хүрээнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлж байна.** Гэвч цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлт зорилтот түвшинд хүрч чадаагүйгээс гадна нүүрсний нийлүүлэлт болон нөөц<sup>7</sup> буурч байгаа зэргээс тус улсад эрчим хүчний хямрал нүүрлэв.
- **Мөн нүүрс төрөгчийн хийг бууруулах 2021 оны зорилтот түвшинд хүрэхээргүй байгаа тул БНХАУ-ын эрх баригчид үйлдвэрлэгчдийг өдрийн цагаар эрчим хүчний хэрэглээгээ бууруулах, ойр ойрхон үйл ажиллагаагаа бүрэн зогсоох шаардлагыг тавьж байна.** Үүнээс шалтгаалан зарим үйлдвэрүүд долоо хоногт 2 өдөр үйл ажиллагаагаа явуулж байгаа талаар албан бус мэдээлэл гарсан бөгөөд энэ нь БНХАУ-ын

төдийгүй дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй.

- Эрчим хүчний нүүрсний нийлүүлэлт 8-р сарын байдлаар 301 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өслөө. Өвөр Монголын Ордосд шинээр үйл ажиллагаа явуулах эрхээ хүлээн авсан эрчим хүчний нүүрсний уурхай нүүрсээ нийлүүлж эхэлсэн, мөн уурхайн ослоос шалтгаалан түр хугацаанд үйл ажиллагаа нь зогсоод байсан Юүлин, Шааньси мужууд дахь уурхайн гарцын хэмжээ хэвийн түвшинд тогтворжсоноор эрчим хүчний нүүрсний нийлүүлэлт бага зэрэг сэргээд байна. Харин БНХАУ-ын дулаан бүс нутгаарх нүүрсний хэрэглээ бага зэрэг буурсан ч 1 өдрийн эрчим хүчний нүүрсний хэрэглээ өндөр хэвээр байна. Эхний 8 сарын байдлаар эрчим хүчний нүүрсний хэрэглээ 1424 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 11 хувиар өссөн байна.
- БНХАУ-ын нүүрсний импортыг 8-р сарын байдлаар АНУ, Индонези, Монгол болон Канад, Орос гэсэн 5 гол орнууд бүрдүүлж байна. **АНУ-ын нүүрсний нийлүүлэлт 8-р сарын нийт импортын 43.1 хувийг дангаараа хангав.**
- Индонези 2021 оны коксжих нүүрсний нийлүүлэлтийг 10 сая тоннд хүргэх зорилтоо нэмэгдүүлж 11.5 сая тонн хүргэхээр зорьж байгаагаа зарлав. Канадын Teck Resources компанийн нүүрсний нийлүүлэлт 2021 онд цар тахалтай холбоотойгоор ажиллах хүчний дутагдал үүссэн болон ойн түймрээс шалтгаалан шинэчлэгдсэн төлөвлөгөөгөөр жилийн 25-26 сая тонн буюу нийт нийлүүлэлтийн хэмжээ бага зэрэг буурахаар байна.

<sup>7</sup> Тус улсын эрчим хүчний нүүрсний нөөцийн хэмжээ 14 хоногийн хэрэгцээг хангах түвшинд хүрч буураад байна.



- **Sxcoal-ийн 9-р сарын 26-ны мэдээгээр коксжих нүүрсний үнэ өмнөх долоо хоногтой ойролцоо буюу 660 орчим ам.доллар байв.** Тяньжин боомт дээрх коксжих нүүрсний үнэ мөн тогтвортой байж 628 орчим ам.доллар байв.
- Гангийн гарц 8-р сард 83.2 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар буурлаа. Гангийн үйлдвэрлэлийн хязгаарлалттай холбоотойгоор гарц буурсан хэдий ч 8-р сарын гангийн экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 37.2 хувиар өсч 3.99 сая тоннд хүрсэн бөгөөд эхний 8 сарын байдлаар гангийн экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 31.6 хувиар өсч 48.2 сая тоннд хүрээд байна.
- БНХАУ Австралийн нүүрсний импортод хориг тавьсаар нэг жил өнгөрч байна. Харин Financial times-ийн 10-р сарын 5-ны мэдээгээр зарим тээврийн компаниуд **Австралийн нүүрсийг бага хэмжээгээр БНХАУ руу нийлүүлж буй талаар мэдээлэв.** Тухайлбал, энэ оны 9-р сард Braemar АСМ 450 мянган тонн нүүрс, Kpler 383 мянган тонн нүүрсийг БНХАУ руу

нийлүүлсэн гэжээ. Шинжээчид үүнийг Австралийн нүүрсний эсрэг хориг суларч буй дохио байж магадгүй гэж үзэж байна.

#### *Монголын нүүрсний нийлүүлэлт*

- Монголын нүүрсний импорт цар тахлаас шалтгаалан хязгаарлагдсан хэвээр байна. Гашуун Сухайт-Ганцмод боомтоор дунджаар нүүрс тээврийн 200 автомашин гарч байгаа бөгөөд тус боомт дээрх нэг тонн коксжих нүүрсний үнэ 9-р сарын 26-ны долоо хоногт 3160 юань буюу 490 орчим ам.долларт хэлбэлзэж байна. Харин Шивээхүрэн-Сэхэ боомт дээрх коксжих нүүрсний үнэ 50 орчим ам.доллараар нэмэгдэж 333 орчим ам.долларт хүрээд байна<sup>8</sup>.

#### *Эх сурвалж:*

1. *Weekly report of 26th of September 2021, Sxcoal*
2. *China Containerized Freight Index, SSE*
3. *China unloads Australian coal despite import ban amid power shortage, Financial Times*

<sup>8</sup> Sxcoal-ийн 2021 оны 9-р сарын 26-ны долоо хоногийн мэдээ.

3

**МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ**

Хүснэгт 1. Экспортын гол нэрийн түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлт

	Бодит гүйцэтгэл						Товч тайлбар
	Үнэ (\$) 2021/09/20	Өөрчлөлт					
		өдрийн	7 хоногийн	сарын	оны эхнээс	жилийн	
<b>Зэсийн үнэ</b>	9,177	0.5	-2.1%	-1.7%	18.4%	34%	Дэлийн хоёр дахь томоохон зэсийн нийлүүлэгч орон болох Перу Улсын зэсийн нийлүүлэлт сэргэж буй нь үнэ буурахад нөлөөлөв. Эрэлт талаас БНХАУ-ын үйлдвэржилт саарч байгаа нь зэсийн эрэлт, үнэ буурахад гол нөлөөг үзүүлж байна.
<b>Төмрийн хүдрийн үнэ</b>	117	0.1%	-1.7%	-17.6%	-32.5%	0.9%	Төмрийн хүдрийн үнэ 5-р сард өмнөх оны мөн үеэс 60 хувийн огцом өсөлтийг үзүүлээд байв. Гэвч гангийн үйлдвэрлэлийн хоригоос шалтгаалан төмрийн хүдрийн эрэлт буурсан юм. Харин 10-р сарын 1-ний БНХАУ-ын үндэсний баяраас өмнө төмрийн хүдрийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор эрэлт бага зэрэг өсөж, үнэ 2021 оны 10-р сарын 4-ний байдлаар 1 тонн төмрийн хүдрийн үнэ 117 ам.долларт хүрч сайжрав. Шинжээчид төмрийн хүдрийн үнэ энэ онд дахин өсөхөөргүй байгаа тухай мэдээлж байна.
<b>Алтны үнэ</b>	1,751	-0.6%	0.1%	-3.5%	-1.1%	-8%	АНУ-ын 9-р сарын 25-ны хөдөлмөр эрхлэлтийн тайланд шинээр ажилд орогсдын тоо 362 мянга буюу төсөөлөл болох 335 мянгаас давсан нь 9-р сард алтны үнэ буурахад нөлөөлөв.
<b>Газрын тосны үнэ (Брент)</b>	79.2	-0.1%	-0.4%	10.6%	55%	92%	ОPEC+ нэгдлийн 2021 оны 10-р сарын 4-ний уулзалтаар 11-р сараас эхлэн газрын тосны гарцын хэмжээг 2022 оны 4-р сар хүртэл 1 өдрийн 0.4 сая/баррелиар нэмэгдүүлэхээр шийдэв. Блүүмбергийн газрын тосны форвард үнэ 2021 оны 4-р улиралд баррель нь 81.8 ам.долларт хүрээд байна.



## Хүснэгт 2. Дэлхийн хамгийн том боомтууд, хүчин чадлаар (2019 оны хүчин чадлаар эрэмбэлсэн)

	Боомтын нэр	Хүчин чадал (2019 он) сая TEU <sup>9</sup>	Хүчин чадал (2021Н1) сая TEU		Боомтын нэр	Хүчин чадал (2019 он) сая TEU	Хүчин чадал (2021Н1) сая TEU
1	Шанхай, БНХАУ	43.3	22.9	9	Тяньжин, БНХАУ	17.2	10.3
2	Сингапур	37.1	18.7	10	Роттердам, Нидерланд	14.8	7.6
3	Нинбо-Жоушан, БНХАУ	27.5	16.1	11	Дубай, АНЭ	14.1	6.9
4	Шэньжэнь, БНХАУ	25.7	13.7	12	Клан, Малайз	13.6	7.0
5	Гуанжоу, БНХАУ	23.2	11.8	13	Сямень, БНХАУ	11.1	5.9
6	Бусан, БНСУ	21.9	11.4	14	Антверп, Бельги	11.1	6.2
7	Чиндао, БНХАУ	21.0	11.7	15	Тайвань, БНХАУ	10.4	4.9
8	Хонг Конг	18.3	8.8	17	Лос Анжелес, АНУ	9.3	10.2

<sup>9</sup> TEU – 20 equipment unit буюу чингэлэг тээврийг зөөх хамгийн жижиг нэгж төхөөрөмж